



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Г “Улаанбаатар АЗЗА” ХК-ийн үнэт цаасны 7
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 11.1, 22.1 дүгээр зүйл, Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 7.1 дэх заалт, Төрийн өмчийн хорооны 2011 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 437 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар АЗЗА” ТӨХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,072,597 /таван сая далан хоёр мянга таван зуун ерэн долоо/ ширхэг энгийн хувьцааг хувь нийлүүлсэн хөрөнгө хасагдуулсантай холбогдуулан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 2,191,362 /хоёр сая нэг зуун ерэн нэгэн мянга гурван зуун жаран хоёр/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Улаанбаатар АЗЗА” ХК/Б.Батмөнх/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН